

БАТЛАВ
ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЬ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
БӨГӨӨД ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН ДАРГА, Б.МӨНХТӨР

**МОНГОЛ УЛСАД ГЕОЛОГИЙН АЛБА ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ
ТҮҮХТ 85 ЖИЛИЙН ОЙГ ТОХИОЛДУУЛАН ЯВУУЛАХ
ГЕОЛОГИЧДЫН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УРАЛДААНЫ
УДИРДАМЖ**

НЭГ. АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УРАЛДААНЫ ЗОРИЛГО

Монгол улсад Геологийн алба үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойг тохиолдуулан Геологийн салбарын хүний нөөцийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, геологийн судалгааны ажилд ашиглаж буй шинэлэг арга, аргачлал, техник технологи, ажлын туршлага зэргийг харилцан солилцох, түгээх, салбарын тэргүүний ажилтан, аж ахуйн нэгжийг шалгаруулах, олон нийтэд үйл ажиллагааг нь сурталчлан таниулахад ажил мэргэжлийн уралдааны зорилго оршино.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

2.1. Уралдааны төрөл, бүрэлдэхүүн

1. Геологийн зураглалын ажил /аж ахуйн нэгжээс оролцох багийн тоо хязгааргүй, нэг багийн бүрэлдэхүүн 3 хүнтэй /

2. Ерөнхий эрлийн ажил /аж ахуйн нэгжээс оролцох багийн тоо хязгааргүй, нэг багийн бүрэлдэхүүн 3 хүнтэй /

3. Геофизикийн ажил /аж ахуйн нэгжээс оролцох багийн тоо хязгааргүй, нэг багийн бүрэлдэхүүн нээлттэй /

4. Зураглал хийх маршрут, эрэл болон геофизикийн талбайг тэмцээн эхлэхээс өмнө оролцох багын тоог харгалзан төлөвлөж, урьдчилан бэлтгэнэ. Төслийн талбайн геологийн ерөнхий мэдээллийг багуудад танилцуулсан байна.

2.2. Уралдааны шалгуур үзүүлэлт:

1. Геологийн зураглалын ажлын төрөлд заасан маршрутын дагуу хээрийн тэмдэглэл хөтлөлт, бичиглэлийн бичсэн байдал, дүгнэлт, зургаар баяжуулсан байдал, боловсруулалт болон бусад

2. Ерөнхий эрлийн ажлын төрөлд сонгосон эрлийн хэсгийн зураг зохиосон байдал баримтжуулалт, сорьцлолт хийсэн байдал, хээрийн тэмдэглэл хөтлөлт болон бусад

3. Геофизикийн ажлын төрөлд өгөгдсөн геологийн даалгаврын дагуу ажиллах, геофизикийн ажлын соронзон судалгааны хээрийн хэмжилт, мэдээллийн боловсруулалт, тайлалт болон бусад

2.3. Шүүгч нарыг сонгох, ирүүлсэн материалтай танилцах, үнэлэх, шалгаруулах:

1. Төрөл тус бүрд гурав гурван шүүгч ажиллах бөгөөд шүүгчийг зохион байгуулах ажлын хэсэг сонгоно.

2. Уралдаанд ирүүлсэн материалыг үнэлэхдээ сонгогдсон шүүгч нар тохиролцон тодорхой интервалтай оноогоор үнэлэн хамгийн их оноо авсан багыг шалгаруулна. Шалгаруулалтыг оролцогч багын тооноос шалтгаалан 1-3 хүртэл байр эзлүүлж болно. Оноо тэнцсэн үед шүүгч нарын олонхын саналаар аль нэгийг нь шалгаруулна.

3. Зохион байгуулах ажлын хэсэг шүүгч нарын үнэлгээг нэгтгэн төрөл тус бүрийн шилдэг баг, шилдэг ААН-ийг шалгаруулна.

2.4. Уралдааны тов: Геологичдын ажил мэргэжлийн уралдаан нь 2024 оны 09 дугаар сарын 27-30 ны өдрүүдэд Булган аймгийн “Оросын булаг” буюу “Эрээн чулуу” ХХК-ийн геологийн судалгааны “Баянзүрх уул” нэртэй төслийн талбайд болно.

1. Геологийн зураглалын ажлын уралдаан 2024 оны 09 дугаар сарын 28-ний өдрийн 10.00 цагт

2. Ерөнхий эрлийн ажлын уралдаан 2024 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 10.00 цагт

3. Геофизикийн ажлын уралдаан 2024 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 10.00 цагт

4. Уралдаанд оролцох аж ахуйн нэгжийн мэдүүлгийг хүлээн авах

Уралдаанд оролцох аж ахуйн нэгжийн албан ёсны хүсэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл хүлээн авах ба уралдаанд оролцох төрөл, багийн мэдүүлгийг Үндэсний Геологийн Албанд буюу зохион байгуулах Ажлын хэсэгт ирүүлнэ.

Хаяг :УБ, СХД 29-р хороо, Үйлдвэрчний эвлэлийн гудамж-37, Үндэсний геологийн албаны байр, 217 тоот өрөөнд

2.5. Уралдааны нээлт, хаалтын үйл ажиллагаа:

“Геологичдын ажил, мэргэжлийн уралдаан”-ы нээлтийн үйл ажиллагаа 2024 оны 09 дугаар сарын 28”ний өдрийн 09.00 цагт “Баянзүрх уул” талбайд эхэлнэ.

2024 оны 09 дугаар сарын 29-ний өдөр уралдаанд шалгарсан баг, аж ахуйн нэгж, геологичдод шагнал гардуулж, хаалтын ажиллагаа болно.

ГУРАВ. ТАВИГДАХ ШААРДЛАГА

1.Уралдаанд оролцох аж ахуйн нэгж, баг нь хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, суурьшлын бүсийн дотоод дэг журмыг мөрдөх, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, тогтоосон газарт байрлуулах,

2.Уралдааны үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг сахих, аливаа асуудал гарвал нэн даруй зохион байгуулагч нарт хандах /утас 99085190/

3.Аж ахуйн нэгжүүд уралдааны нээлт, хаалтын жагсаалд барих болон талбайд байрлуулах туг, далбаа эсвэл хаяг бүхий самбартай байх, уралдаанд оролцох багууд ижил хувцастай байх

4.Уралдаанд оролцох хувийн бэлтгэл хангах, (гэр майхан, хоол хүнс, ус, геологийн алх, луп, компас, GPS, геофизикийн хэмжилтийн багаж, бичгийн хэрэгсэл болон шатар, бөхийн өмсгөл зэрэг гм)

5.Уралдааны үеэр гарах аливаа асуудлыг тухай бүр багийн ахлагч нар, зохион байгуулагч болон уралдааны ерөнхий шүүгчтэй хамтран шийдвэрлэх,

ДӨРӨВ. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

Аж ахуйн нэгжийн оролцох төрөл, багийн тоог хязгаарлахгүй бөгөөд баг тус бүрийн тоогоор 500000 төгрөгийн хураамжийг шагналын санд төвлөрүүлэх ба төрөл тус бүрд оролцох багийн тооноос үл хамааран шагналын сан дах хуримтлалыг шагналт байруудад шат дараалалтайгаар ижил хуваарилна.

Жич : Хураамжийг “Монголын геологийн холбоодын нэгдсэн зөвлөл”-ийн “Хаан” банкны **5028971033** тоот дансанд 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс өмнө байршуулах ба гүйлгээний утга хэсэгт аж ахуйн нэгжийн нэр болон “уралдаан” гэж заавал бичнэ.

Үндсэн 3 ажлын төрлүүд тус бүрийг багаар эхний 1-3 байр шалгаруулж, дүнг нэгтгэн аж ахуйн нэгжүүдийг шүүгчдийн баг үнэлж шалгаруулна. Байр эзэлсэн баг, аж ахуйн нэгжийг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ:

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ, ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА,
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР, ШУА ГЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН,
ШУТИС, ГЕОЛОГИ УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ, МУИС-ИЙН ШУС-ИЙН
БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР ГЕОЛОГИ, ГЕОФИЗИКИЙН ТЭНХИМ,
МОНГОЛЫН ГЕОЛОГИЙН ХОЛБООДЫН НЭГДСЭН ЗӨВЛӨЛ ТББ**

2024 ОН